

Бурханд хүрэх зам





БУРХАН ДЭЛХИЙ БОЛОН ТҮҮНД АМЬДРАГЧ БҮХНИЙГ БҮТЭЭЖЭЭ

1

"Эхэнд Бурхан тэнгэр газрыг бүтээжээ ..."

- *Эхлэл 1:1*

"Учир нь Түүн дотор тэнгэр ба газар дахь бүх юмс ... бүтээгдсэн байна ..."

- *Колоссай 1:16*

"Та нар тэнгэр ба газрыг бүтээгч ЭЗЭНээс ерөөл хүртэх болтугай! Тэнгэрүүд бол ЭЗЭНий тэнгэрүүд билээ. Харин газар дэлхийг Тэрээр хүний хөвгүүдэд өгсөн ..."

- *Дуулал 115:15, 16*

Бурхан дэлхийг бүтээхэд дэлхий төгс байсан. Цаашид юу болсон тухай энэ номноос уншаарай.

БУРХАН БИДНИЙГ БҮТЭЭСЭН



“Бид Өөрсдийнхөө дүр төрхийн дагуу Өөрсөдтэйгээ адилхан хүнийг бүтээж ... бүгдийг тэдэнд захируулъя ...” - *Эхлэл 1:26*

ХҮН АМИН АМЬСГАЛТАЙ БОЛЖЭЭ

3

“ЭЗЭН Бурхан тоос шорооноос хүнийг бүтээж, амин амьсгалыг хамраар нь үлээж оруулахад, хүн амьд оршигч болжээ ...”

- *Эхлэл 2:7*

“ЭЗЭН Бурхан Хүн ганцаараа байх нь сайн биш учир Би түүнд тохирох туслагчийг бүтээе ..., ЭЗЭН Бурхан Адамыг гүн нойронд автуулж, түүнийг унтаж байх зуур хавиргаас нь нэгийг сугалж аваад, ормыг нь махаар бөглөжээ. ЭЗЭН Бурхан Адамаас авсан тэр хавиргаараа эмэгтэй хүн бүтээгээд, түүнийгээ Адамд авчирч өгөв.

- *Эхлэл 2:18, 21-22*

Амин амьсгал нь хаа нэгтээ мөнхөд байна гэсэн үг.

4 АДАМ ЕВА ХОЁР БУРХАНЫ ТУШААЛЫГ ЗӨРЧЖЭЭ



Бид хэзээ ч Сатаны дууг сонсохгүй байх ёстой.

“ЭЗЭН Бурхан хүнийг аваад, Еден цэцэрлэгийг арчлуулан сахиулахын тулд тэнд суулгав. Эзэн Бурхан тэр хүнд тушаан ийнхүү өгүүлэв: Чи энэ цэцэрлэгийн аль ч модны жимсийг дураараа идэж болно. Харин чи сайн мууг мэдүүлэгч модны жимснээс огт идэж болохгүй. Чи түүнээс идсэн тэр өдөртөө л зайлшгүй үхнэ! хэмээн айлдав ...”

- *Эхлэл 2:15-17*

АЛБИН БУЮУ БУГ ГЭЖ НЭРЛЭГДДЭГ МОГОЙ БУРХАНЫ ЭРХ МЭДЭЛД ХАЛДАЖ ХУДАЛ ХЭЛСЭН ЮМ

“Тэр могой эмэгтэйд: Та нар ерөөс үхэхгүй ... Тэгээд тэр модны жимс нь хүнс болоход шимтэй, нүд булаам, мэргэн ухаантай болгочихмоор, шунал хөдөлгөм сайхан харагдсан тул тэр эмэгтэй түүнээс авч иджээ. Тэр ба нөхөртөө өгч, тэр ч иджээ.”

- *Эхлэл 3:4, 6*

АДАМ ЕВА ХОЁР ЦЭЦЭРЛЭГТ БАЙХ АРГАГҮЙ БОЛОВ



“ЭЗЭН Бурхан хүнийг өөрийг нь гаргаж авсан газар шороог хагалуулахаар Еден цэцэрлэгээс гарган явуулж ... амийн мод уруу хөтлөх замыг хамгаалуулахаар ... зүүн талд херубууд болон зүг бүрд эргэлддэг галт илдийг байрлуулан тавьжээ.

- Эхлэл 3:23, 24

**АДАМ ЕВА ХОЁР НҮГЭЛД УНАСАН НЬ ХҮН ТӨРӨЛХТНИЙ 7
ХУВЬД ХАМГИЙН ГУНИГТ ӨДӨР БОЛСОН ЮМ**



“Нэг хүнээр ертөнцөд нүгэл нь ирсний адил нүглээр үхэл нь ирсэн. Тиймээс бүгд нүгэл үйлдсэн тул үхэл нь бүх хүнд иржээ.”

- Ром 5:12

Үргэлж санаж байх зүйл

Үхэл нүглээр ирсэн тул хүн болгон төрөхдөө нүгэлд төрсөн бөгөөд нэгэн өдөр үхэх болно.

- Ром 5:12-г дахин унш

БУРХАН БИДНИЙГ НҮГЛЭЭС

АВРАХ ГЭЖ ӨӨРИЙН

ГАНЦ ХҮҮГЭЭ ИЛГЭЭЖЭЭ



“Түүнийг хүү төрүүлэхэд, чи Түүнийг Есүс гэж нэрлэ. Учир нь Тэр Өөрийн ард түмнийг нүглээс нь аварна.”

- *Матай 1:21*

Учир нь бүх Бурханлаг бүрэн дүүрэн нь Түүн дотор биет хэлбэрээр оршдог.

- *Колоссай 2:9*

ЕСҮС ХҮНИЙ БИЕЭР ИРСЭН БУРХАН

9

“Эхэнд Үг байсан. Үг Бурхантай хамт байсан ба Үг нь Бурхан байсан ... Үг нь махан бие болж бидний дунд оршин байв ...”

- *Иохан 1:1, 14*

“Эдүгээ энэ бүхэн тохиолдсон нь ...” Харагтун, онгон бүсгүй Хүүхэдтэй болж Хүү төрүүлнэ, Тэгээд тэд Түүнийг Иммануел (орчуулбал “Бурхан бидэнтэй хамт”) гэж нэрлэнэ гэсэн юм.

- *Матай 1:22, 23*

“Учир нь бидний төлөө хүүхэд төрж, бидэнд хүү өгөгдөнө. Засаглал Түүний мөрөн дээр байх болно. Түүний нэрийг Гайхамшигт Зөвлөгч, Хүчит Бурхан, Мөнхийн Эцэг, Энхийн Жонон гэж дуудна.”

- *Исаиа 9:6*

ЕСҮС ХРИСТ - БИДНИЙ ӨРГӨЛ

“... нүглийг үл Мэдэгч ...”

- *2 Коринт 5:21*

“Тэр нүгэл үйлдээгүй ...”

- *1 Петр 2:22*

Хүн ямар ч өргөл өргөсөн нүглээ цагаатгаж чадахгүй байв. “Учир нь бух, ямааны цусаар нүглийг авч хаях боломжгүй юм”

- *Еврей 10:4*

Есүс бол Бурханы хурга.

“Ертөнцийн нүглийг үүрэгч Бурханы Хургыг харагтун!”

- *Иохан 1:29б*



ЕСҮС БИДЭНД ӨӨРИЙН АМЬДРАЛАА ӨГСӨН 11

Нүгэлтнүүд Есүсийг үзэн ядаж байсан тул Түүнийг модон загалмайд хадав. Гэвч түүний үхэл Бурханы төлөвлөгөө байжээ. Есүс та биднийг нүглээс маань аврахын тулд сайн дураараа амиа өгсөн юм.

Есүс хэлэхдээ: Хэн ч Миний амийг Надаас авахгүй. Харин Би Өөрийн санаагаар түүнийг өгнө. Амиа өгөх эрх мэдэл Надад бий. Буцааж авах эрх мэдэл ч Надад бий...
- *Иохан 10:18*

БИД БУРХАНЫ ХУРГАНЫ ЦУСААР ТӨЛӨГДСӨН


“... харин гэм зэмгүй агаад толбогүй хурганы цус адил Христийн цусаар солигдсон гэдгээ мэдэгтүн.”

ГЭМЭЭС АВРАХ ӨӨР ӨРГӨЛ БАЙХГҮЙ

“Энэхүү хүслээр бид Есүс Христийн нэг удаа бүгдийн төлөө биеэ өргөсөн өргөлөөр дамжуулан ариусгагдсан юм.”
- *Еврей 10:10*

12 “... Түүний цусаар зөвтгөгдсөн бид тэр тусмаа Түүгээр
дамжуулан уур хилэнгээс ч аврагдах болно.”
- Ром 5:9

Есүс ээ, Та Өөрийнхөө хаанчлалд
ирэхдээ намайг санаарай.



Энэ хоригдол
Есүст итгэж
аврагдсан.

“Үнэнээр Би чамд
хэлье. Өнөөдөр чи
Надтай хамт
Диваажинд байх
болно” –Лук 23:43

Энэ хоригдол
Есүст итгээгүй
бөгөөд
аврагдаж
чадаагүй.

“... Христ бидний төлөө үхсэн. Үүгээрээ Бурхан биднийг хайрлах
хайраа харуулсан юм.”
- Ром 5:8

БУРХАНЫ ХҮҮД ИТГЭСЭН ХҮН АМЬТАЙ

13

Бурхан ертөнцийг үнэхээр хайрласан
тул цорын ганц Хүүгээ өгсөн.

Ингэснээр Хүүд итгэгч хэн ч
мөхөхгүй, харин мөнх амьтай болох юм.

- Иохан 3:16

Учир нь Тэр биднийг харанхуйн эрх мэдлээс авраад, Өөрийн хайрт Хүүгийнхээ хаанчлалд шилжүүлсэн юм. Хүүгийнх нь дотор бидэнд нүглийн уучлал болох золилт байна.

- Колоссай 1:13, 14

Аврах гэдэг нь үнээр худалдаж авсан гэсэн утгатай.

“ТЭР АМИЛСАН!”

“Тэгтэл тэнгэр элч эмэгтэйчүүдэд: Бүү ай. Загалмайд цовдлогдсон Есүсийг хайж байгааг чинь би мэдэж байна. Тэр энд байхгүй. Учир нь хэлж байснаараа Тэр амилсан. Ирэгтүн. Түүний хэвтэж байсан газрыг үзэгтүн.”

- *Матай 28:5, 6*

ЕСҮС ҮХЛЭЭС АМИЛСАН

15

“Амьд Нэгэн мөн. Би үхсэн байсан. Харагтун. Би үеийн үед амьд байна. Надад үхэл ба үхэгсдийн орны түлхүүр бий.”

- *Илчлэлт 1:18*

“... Яагаад гэвэл Би амьд байна. Та нар ч амьд байна.”

- *Иохан 14:19*

“Айх үедээ би Танд итгэлээ өгнө.”

- *Дуулал 56:3*

“Гэтэл нөгөө талаас Тэр мөнхөд байдаг тул Өөрийн тахилчийн үүргийг байнга барьдаг. Тиймээс Тэр Өөрөөр нь дамжуулан Бурханд ойртогсдыг бүрэн төгс аврах чадвартай. Учир нь Тэр тэдний төлөө зуучлан залбирахын тулд үргэлж амьд байдаг.”

- *Еврей 7:24, 25*



Чи аль замаар нь явах вэ?
Есүс Христ бол Мөнхийн амьдралд хүрэх зам мөн. Чөтгөр (Сатан) бол мөнхийн үхэл уруу хөтлөх зам мөн. Энэ жаал Мөнхийн амьдралд хүрэх зөв сонголтыг хийжээ.

ТА ЯМАР СОНГОЛТ ХИЙХ ВЭ?

17

“... Эзэнд үйлчлэх нь та нарын хувьд нийцгүй мэт байвал, хэнд үйлчлэх вэ? гэдгээ өнөөдөр өөрсөддөө сонго...”

- *Иошуа 24:15*

“... Чи болон чиний үр удам амьдрахын тулд амийг сонго...”

- *Дэд хууль 30:19*

ЕСҮС БОЛ МӨНХИЙН АМЬДРАЛД ХҮРЭХ ЗАМ

“Өөр хэний ч дотор аврал үгүй. Учир нь бид аврагдаж болох өөр нэр тэнгэрийн дор хүмүүст өгөгдсөнгүй.”

- *Үйлс 4:12*

“Би, зөвхөн Би бол ЭЗЭН мөн бөгөөд Надаас өөр Аврагч байхгүй.”

- *Исаиа 43:11*

18 **МӨНХИЙН АМЬТАЙ БОЛОХЫГ ХҮСВЭЛ
ЯАГААД ЕСҮСИЙГ СОНГОХ ХЭРЭГТЭЙ ВЭ?**

1. Дээрээс ирсэн нь Есүс Христ тул



“... Би тэднийг амьтай, бялхсан амьтай байлгахын тулд ирсэн.”
- *Иохан 10:10*

2. “Христ биднийг хайрлаж, амиа өгсөн тул”

“... миний төлөө Өөрийгөө тушаасан Бурханы Хүүд итгэх итгэлээр амьдарч...”
- *Галат 2:20*

Есүс бидэнтэй адилхан махбодь ба цустай хүн болсон.

“Тийнхүү хүүхдүүд нь цус ба махан биеийн тасархай болов. 19 Түүнчлэн Тэр Өөрөө бас тасархай болсон. Ингэснээр Тэр үхлийн хүч буюу диаволыг үхлээрээ устгаж, бүх насаараа үхлийн айдсаар боолчлогдож байсан тэдгээр хүмүүсийг чөлөөлөх юм.”

- *Еврей 2:14, 15*

3. Зөвхөн Есүсийн цус л бидний гэмийг ариусгаж чадна.

“... цус бол амийн төлөө эвлэрүүлтийг хийдэг юм.”

- *Левит 17:11*

“... түүний Хүү Есүсийн цус биднийг бүх нүглээс ангижруулдаг ажээ.”

- *1 Иохан 1:7*

“Хүүгийнх нь дотор бидэнд нүглийн уучлал болох золилт байна.”

- *Колоссай 1:14*



4. Зөвхөн Христ үхлээс амилсан юм.

“Христ үхэгсдээс амилуулагдсан тул дахиж хэзээ ч үхэхгүйг бид мэднэ. Үхэл цаашид Түүнийг захирахгүй.”

- *Ром 6:9*

“Тэр бүгдийн төлөө үхсэн учраас амьд байгсад цаашид өөрсдийн төлөө бус, харин өөрсдийнх нь төлөө үхээд, амилуулагдсан Түүний төлөө амьдрах ёстой.”

- *2 Коринт 5:15*

Есүс хэлэхдээ: “... Яагаад гэвэл Би амьд байна. Та нар ч амьд байна.”

- *Иохан 14:19*

5. Мөнх амьдрахын тулд Христийн Сүнсийг хүлээн авах хэрэгтэй. 21

“... Энэ нь та нарын дотор байгаа алдрын найдвар болох Христ мөн.”

- Колоссай 1:27б

“Мөн үхэгсдээс Есүсийг амилуулсан Нэгэний Сүнс та нарын дотор оршвоос, Христ Есүсийг үхэгсдээс амилуулсан Тэр та нарын дотор оршдог Өөрийн Сүнсээр дамжуулан үхлийн биест чинь амь өгнө.”

- Ром 8:11

**ХРИСТИЙН СҮНС ТАНЫ ДОТОР АМЬДРАХ
ЁСТОЙГ АНХААРААР**

“... Хэрэв хэн нэгэнд Христийн Сүнс байхгүй бол тэр Түүнийх биш.”

- Ром 8:9

ЧИ ЯАЖ МӨНХИЙН АМИЙГ ОЛОХ ВЭ?

24-р хуудсанд
байгаа зааврыг
дага



“Хөвгүүний биеэ авч
явж буй нь шударга
зөв эсэхийг юу
хийдгээр нь
мэдэж болно.”

Есүс надад хайртай, үүнийг би мэднэ.
Мөн Библи надад хэлсэн.

ЕСҮС БҮХ ХҮҮХДҮҮДЭД ХАЙРТАЙ

23

“Есүс тэднийг дуудаад, Хүүхдүүдийг Над уруу ирүүл. Тэднийг бүү саатуул. Учир нь Бурханы хаанчлал ийм л хүмүүсийнх юм шүү.”

- *Лук 18:16*

“Тиймд эдгээр багачуудаас хэн нэг нь эрсдэх нь тэнгэрт байгаа Эцэгийн тань хүсэл биш юм.”

- *Матай 18:14*

Чи хэн ч бай, хаана ч байсан Есүс чамд хайртай, чиний төлөө нас барсан юм. Тэр мөн чиний хайрыг үгүйлж байна. Есүсийг дагасанаар Түүнд хайраа харуулж буй хэрэг.

“Хэрэв та нар Намайг хайрладаг бол, Миний тушаалуудыг сахь.”

- *Иохан 14:15*

ЧИ ЯАЖ БУРХАНЫГ ОЛОХ ВЭ?

1. Чи гэмтэй гэдгээ хүлээн зөвшөөр (Гэм гэдэг нь Бурханы тушаалыг биелүүлэхгүй байх гэсэн утгатай).

“Бүгд нүгэл үйлдсэнээр Бурханы алдарт хүрдэггүй.”

- *Ром 3:23*

2. Есүс Христээр дамжин Бурханд хүрнэ.

“Учир нь ганц Бурхан байна. Мөн Бурхан ба хүмүүсийн хооронд ганц зууч байна. Тэр нь хүн болох Христ Есүс билээ.”

- *1 Тимот 2:5*

“Тиймээс Тэр Өөрөөр нь дамжуулан Бурханд ойртогсдыг бүрэн төгс аврах чадвартай...”

- *Еврей 7:25*

“Эцэгийн Надад өгдөг бүхэн Над уруу ирнэ. Над уруу ирэх хүнийг Би огт хөөж гаргахгүй.”

- *Иохан 6:37*

3. Өөрийн нүглүүдээ гэмш.

(миний гэмийг уучлаач гэж заавал гэмшин хэлээрэй!)

“Иймээс гэмшицгээ. Нүглүүдээсээ салахын тулд эргэцгээ...”


- *Үйлс 3:19*

“Эзэн ... хэнийг ч мөхүүлэхийг хүсэлгүй, бүгдийг гэмшилд ирээсэй хэмээн хүсэн та нарт тэвчээртэй ханддаг.”

- *2 Петр 3:9*

4. Чи Есүсийн өмнө гэмш.

(заавал гэмээ улайж, Түүнд хэл)



Хэрэв бид нүглээ
хүлээн зөвшөөрвөл
Тэрээр итгэмжнт,
зөвт бөгөөд
бидний нүглийг
уучилж, бүх л зөвт
бус байдлаас
биднийг
цэвэрлэнэ.

-1 Иохан 1:9

26 25-р хуудасны залбирч буй гар дээр байгаа
1 Иохан 1:9 ишлэлийг доор бичнэ үү.

.....
.....
.....
.....

5. Өөрийн гэмүүдийг бүрмөсөн хая.

“Гэм нүглээ нуун далдлагч хэзээ ч амжилтад хүрэхгүй.
Харин гэм нүглээ хүлээн зөвшөөрч, тэдгээрийг мартдаг хүн хайр
энэрлийг хүртэнэ.”

- Сургаалт үгс 28:13

“Бузраас хагацаж, сайныг үйлд! Тэгвэл чи мөнхөд орших
болно.”

- Дуулал 37:27



“Хэрэв та Есүсийг Эзэн гэж амаараа хүлээн зөвшөөрч, Бурхан Түүнийг үхэгсдээс амилуулсан гэдэгт зүрхэндээ итгэвэл, аврагдаж болно.”

- *Ром 10:9*

Тэд “Эзэн Есүст итгэгтүн. Чи болон гэрийнхэн чинь ч аврагдана, гэлээ”

- *Үйлс 16:31*

“Учир нь нигүүлслээр та нар итгэлээрээ аврагдсан юм. Энэ нь та нараас биш харин Бурханы бэлэг бөгөөд үйлсээр биш аж. Тиймээс хэн ч өөрөөрөө сайрхахгүй болно.” - *Ефес 2:8, 9*

28 7. Өөрийн зүрх сэтгэл, амьдралдаа Есүс Христийг хүлээн ав.

Чи Түүнд зүрх сэтгэлийнхээ хаалгыг нээж чадна.



“Харагтун. Би үүдэн дээр зогсоод тогшиж байна. Хэрэв хэн нэгэн нь Миний дууг сонсоод хаалгаа нээвэл, Би түүний дотор орж, түүнтэй хамт, тэр Надтай хамт хооллоно.”

- *Илчлэлт 3:20*

“Харин Өөрийг нь хүлээн авсан болгонд, Өөрийнх нь Нэрд итгэдэг хүмүүст Бурханы хүүхэд болох эрхийг Тэр өгөв.”

- *Иохан 1:12*

Хэрэв та хэзээ ч залбирч үзээгүй бөгөөд тусламж хэрэгтэй байгаа бол дараах байдлаар залбирна уу:



Их Эзэн Есүс минь ээ! Миний нүглийг загалмай дээр үүрсэн Танд баярлалаа. Хийсэн бүх нүглийг минь өршөөгөөч. Миний зүрх сэтгэлд орж ирээч гэж гуйж байна. Яг одоо миний зүрхийг ариусгана гэдэгт би итгэж байна. Таныг амьдралынхаа Аврагч Эзэн болгож байна.

Есүсийн
Нэрээр, Амен.

30 **ЕСҮС ЧИНИЙ ЗҮРХ СЭТГЭЛД БАЙДАГ
БӨГӨӨД ЧАМД МӨНХИЙН АМЬДРАЛЫГ ӨГСӨН**

“... Бурхан бидэнд мөнх амийг өгсөн бөгөөд энэхүү амь нь Түүний Хүүгийн дотор байна. Хүүтэй хүнд амь бий. Бурханы Хүү байхгүй хүнд амь байхгүй.”
- 1 Иохан 5:11, 12

“... Миний үгийг сонсоод, Намайг илгээгч Түүнд итгэгч нь мөнх амьтай болох бөгөөд яллагдахгүй. Харин үхлээс өнгөрч амь уруу шилжив.”
- Иохан 5:24

Таны бие үхэхэд, та өөрөө Бурхантай хамт байх болно.

- 2 Кор 5:8

“... та нарын дотор байгаа алдрын найдвар болох Христ мөн.”

- Колоссай 1:27

Хэрэв та Есүсийн өмнө гэмшиж, Түүнийг өөрийнхөө Аврагч гэж итгэж байгаа бол нэрээ бичнэ үү!



Өдөр болгон Бурханы Үг болох Библиэс уншиж, таньд туслах онцгой ишлэлүүдийг цээжлэн зүрхэндээ хадгал. (Энэ номонд олон ишлэл бий)

“Судар бүр Бурханы амьсгалснаар байгаа бөгөөд заахад, зэмлэхэд, залруулахад, зөвт байдал дотор чиглүүлэхэд тустай.”

- 2 Тимот 3:16

ЦАГ БҮР ЗАЛБИРАЛ ДОТОР ЕСҮСТЭЙ ЯРЬ



Амьдралынхаа сайн сайхан бүхний төлөө
Есүст таларх. Таны амийг аварч, таны
төлөө хийсэн бүх зүйлсийн төлөө Түүнийг
магт. Хэрэгтэй бүхнийхээ төлөө Есүсийн
нэр дээр залбир.

“... бид Түүний хүслийн дагуу юуг ч гуйвал,
Тэр биднийг сонсдог...” - *1 Иохан 5:14*

“... Хэрэв та нар Миний нэрээр Эцэгээс
минь юуг ч гуйвал Тэр түүнийг чинь өгнө.”
- *Иохан 16:23*

“... Бие биенийхээ төлөө залбир...”
- *Иаков 5:16a*

“... дайснуудаа хайрла, та нарыг хавчдаг
хүмүүсийн төлөө залбир.” - *Матай 5:44*

ЕСҮС ЗАЛБИРЛЫН ТУХАЙ ӨӨРИЙН ШАВЬ НАРТАА ЗААЖ СУРГАСАН НЬ

33

*(Шавь гэдэг нь Есүсийг дагаж байсан
хүтүүсийг хэлнэ)*

Есүс шавь нартаа ийнхүү залбирахыг хэлж өгсөн:

“Тэнгэрт байгаа бидний Эцэг минь, Таны нэр ариунаар дуурсагдаг. Таны хаанчлал ирэх болтугай. Хүсэл тань тэнгэрт шигээ газар дээр биелэгдэх болтугай. Өдөр тутмын минь талхыг энэ өдөр бидэнд өгөөч. Бид өртөнгүүдээ уучилсны адил бидний өрийг мөн уучлаач. Биднийг сорилтод бүү оруулаач. Харин бузар муугаас гэтэлгээч. Учир нь хаанчлал, хүч чадал, алдар сүр үүрд Таных. Амен.”

- *Матай 6:9-13*

Чи энэхүү залбирлыг цээжлээрэй.

34 **БУРХАНЫ АРВАН ХУУЛЬ БИДЭНД ХЭРХЭН
АМЬДРАХЫГ СУРГАДАГ**

(Египетээс гарсан нь: 20-р бүлэг)

Эхний дөрвөн хууль нь Бурханыг хайрлах тухай

1. “Чи надаас өөр бурхадтай байж болохгүй!”
2. “Чи өөртөө зориулан шүтээн эсвэл дээр тэнгэр дэх, доор газар дахь, газрын доор усан доторх юмны ямар нэг дүрсийг бүү хий!”
3. “Чи өөрийн Бурхан ЭЗЭНий нэрийг дэмий бүү дурд!”
4. “Амралтын өдрийг ариунаар сахихын тулд санагтун!”

Дараагийн зургаа нь хүнийг хайрлах тухай заадаг.

5. “Чи эцэг эхээ хүндэл!”
6. “Чи хүн бүү ал!”
7. “Чи бүү завхайр!”
8. “Чи бүү хулгайл!”
9. “Чи хөршийнхөө эсрэг худал бүү гэрчил!”
10. “Чи хөршийнхөө гэр оронд бүү шунахайр! ... юунд ч бүү шунахайр!”

**БИД БУРХАНД ТААЛАМЖИТ УЧРААС ЗАЛБИРЛЫН
МААНЬ ХАРИУЛТ ИРДЭГ**

“Гуйсан болгоноо Түүнээс хүлээн авна. Учир нь бид Түүний тушаалуудыг сахьж, Түүний мэлмийд тааламжтай зүйлсийг үйлддэг билээ.”

- 1 Иохан 3:22

ХОЁР АГУУ ТУШААЛ БАЙДАГ

Бурханаа хайрла

Нэгт.

Есүс түүнд “Чи бүх зүрх, бүх сэтгэл, бүх оюун ухаанаараа өөрийн Бурхан Эзэнээ хайрла.”

- *Матай 22:37, 38*

Хүнийг хайрла

Хоёрт.

“Удаах нь “Чи хөршөө өөрийн адил хайрла” гэсэнтэй адил юм.”

- *Матай 22:39*



ХАЙР БОЛ БҮГДЭЭС АГУУ

37

Агуу хайрын тухай (1 Коринт 13:1-8, 13)

“Хэрэв би хүмүүсийн болон тэнгэр элч нарын хэлээр ярьсан ч надад хайр байхгүй бол би нүргэлэх харанга, хангинах цан болох байсан. Хэрэв би эш үзүүлэх чадвартай, мөн бүх нууцууд болон бүх мэдлэгийг мэддэг байгаад, уулыг нүүлгэх бүрэн итгэлтэй байлаа ч, надад хайр байхгүй бол би юу ч биш. Хэрэв би өөрийн бүх л өмч хөрөнгөө тараан өгч, өөрийн биеийг шатаахаар тушаасан ч, надад хайр байхгүй бол энэ нь надад ямар ч ашиггүй юм. Хайр бол тэвчээртэй, энэрэнгүй юм. Хайр атаархдаггүй, бардам зан гаргадаггүй, ихэрхдэггүй, зохисгүй авирладаггүй, өөрийнхийг эрдэггүй, уурладаггүй, муутай тооцоо хийдэггүй, зөв бус байдалд баярладаггүй, харин үнэнд

баярладаг, бүгдийг далдалдаг, бүгдэд итгэдэг, бүгдэд найддаг, бүгдийг тэсвэрлэдэг. Хайр хэзээ ч дуусдаггүй. Харин эш үзүүлж байгаа бол, тэдгээр нь үгүй болно. Хэрэв олон янзын хэлүүд байгаа бол тэд болих болно. Хэрэв мэдлэг байгаа бол энэ ч үгүй болно. Эдүгээ итгэл, найдвар, хайр гурав үлддэг боловч хамгийн агуу нь хайр мөн.“

БУРХАН БОЛ ХАЙР

“Бурханы биднийг хайрладаг хайрыг нь бид мэдэж, итгэдэг“

- 1 Иохан 4:16

ЧАМАЙГ БУСДАД ГЭРЧЛЭГЧ БАЙГААСАЙ ГЭЖ ЕСҮС ХҮСЭЖ БАЙНА

39

*(гэртээ, сургууль дээр, сүтд,
хаана ч)*

Есүс зөвшөөрсөнгүй, харин түүнд: “Гэртээ, өөрийнхөн дээрээ оч. Эзэн чамд ямар агуу зүйлс хийж, чамд хэрхэн өршөөлөө үзүүлснийг тэдэнд мэдэгд” гэв.

- Марк 5:19



БУРХАНЫ ЖИНХЭНЭ ХҮҮХДҮҮДИЙГ ЯАЖ МЭДЭХ ВЭ?

“Ийнхүү та нар тэднийг үр жимсээр нь танина.”

- Матай 7:20

“Харин Сүнсний үр жимс нь хайр, баяр баясгалан, амар тайван, тэвчээр, энэрэл, сайхан сэтгэл, итгэлтэй байдал, дөлгөөн зан, өөрийгөө захирах юм ...”

- Галат 5:22-23

БУРХАНЫ ЖИНХЭНЭ ХҮҮХЭД БУСДЫГ УУЧИЛДАГ

“... та нар хүмүүсийн алдааг уучилбал тэнгэрлэг Эцэг тань та нарыг мөн уучилна.”

- Матай 6:14

ЭЗЭН 7-Н ЗҮЙЛИЙГ ҮЗЭН ЯДДАГ: “Ихэмсэг харц, худалч хэл, ... цусыг урсгагч гар, хар буруу төлөвлөгөөг сэдэгч зүрх, хорон муу уруу түргэн гүйгч хөл, ... хуурамч гэрчлэгч, ... эвдрэлцлийг тараагч ...”

- Сургаалт үгс 6:17-19

МАХАН БИЕЙН ҮЙЛС

41

Сүнсний



Махан
биеийн
үйлсүүд

“... завхайрал, бузар байдал, ... шүтээн шүтэх, ид шид, дайсагнал, маргаан, ... уур хилэн, өрсөлдөөн, хагарал, тэрс үзэл санаа, атаархал, архидалт, утга учиргүй наргиж цэнгэх ... зүйлсийг үйлдэгчид нь Бурханы хаанчлалыг өвлөхгүй.”

- Галат 5:19-21


“... ижил хүйстэнтэйгээ нөхцөгчид ч, ... хулгайч нар ч, шуналтангууд ч ...”

- 1 Коринт 6:9-10

“... Гэвч Эзэн Есүс Христийн нэрээр болон бидний Бурханы Сүнс дотор ... угаагдсан ...”

- 1 Коринт 6:11

ТАМ ГЭДЭГ БОЛ БОДИТ ГАЗАР



(Лук 16:19-26)

Зөвхөн Есүс Христэд итгээрэй.
Тэр л таны нэрийг Амийн Номдоо
бичих болно.

“Хэрэв хэн нэгний нэр амийн
номд бичигдсэн нь олдохгүй
бол Тэр хүн галт нуурт хаягдсан
байна.”

- Илчлэлт 20:15

ЕСҮС БУРХАНД ХҮРЭХ ЦОРЫН ГАНЦ ЗАМ 43

“... Бурхан бидэнд мөнх амийг өгсөн бөгөөд энэхүү амь нь Түүний Хүүгийн дотор байна.”
- *1 Иохан 5:11*

“Учир нь нүглийн хөлс бол үхэл, харин Бурханы бэлэг бол бидний ЭЗЭН Христ Есүс доторх мөнх амь мөн.”
- *Ром 6:23*

“Хүүд итгэдэг хүн мөнх амьтай. Харин Хүүд итгэдэггүй хүн мөнх амийг үзэхгүй. Харин Бурханы уур хилэн тэр хүн дээр байдаг.”
- *Иохан 3:36*

Есүс “Би бол зам, үнэн, амь мөн. Хэн ч Надаар дамжилгүйгээр Эцэгт хүрэхгүй.”
- *Иохан 14:6*

ДИВААЖИН БОЛ БОДИТ ГАЗАР

Илчлэлт 21 дээр Иохан шинэ тэнгэр ба шинэ газрын тухай хэлсэн байдаг.

“Тэр тэдний нүднээс нулимс бүрийг нь арчина. Тэнд цаашид үхэл байхгүй болно. Тэнд цаашид гашуудах, уйлах, өвдөх гэж үгүй болно. Анхны юмс өнгөрөн одлоо ... Харатун! Би бүх юмсыг шинэчилнэ ...”

- *Илчлэлт 21:4, 5*



Иохан цаашлаад Ариун хот Шинэ Иерусалимын тухай хэлэхдээ: “хот нь тунгалаг шил мэт шижир алт ... Хотын хэрмийн сууриуд нь төрөл бүрийн

эрдэнийн чулуугаар чимэглэгджээ.”

- *Илчлэлт 21:18, 19*

ЕСҮС ӨӨРТ НЬ ИТГЭГЧ ХҮМҮҮСИЙН ТӨЛӨӨ 45
ОРОН ГЭР БЭЛДЭХЭЭР ЯВСАН

“Та нар зүрхээ бүү зовоо. Бурханд итгэ, мөн Надад итгэ. Миний Эцэгийн гэрт орон байр олон бий. Хэрэв тийм биш байсан бол Би та нарт хэлэх байсан. Би та нарт орон байр бэлдэхээр явна. Хэрэв Би явж та нарт орон байр бэлдвэл, дахин ирж, та нарыг Өөртөө авна. Би хаана байна, та нар мөн тэнд байх болно.”

- Иохан 14:1-3

ЭНЭ САЙН МЭДЭЭГ БУСДАД ХЭЛ

“Бүх дэлхийгээр явж, сайн мэдээг бүх бүтээлд тунхаглагтун.

- Марк 16:15

“... Мэргэн хүн сэтгэлийг байлдан дагуулна.”

- Сургаалт үгс 11:30б

46 ТҮҮНИЙ ХҮҮХДҮҮДЭД ЗОРИУЛСАН АМЛАЛТ

“... Би чамайг хэзээ ч орхихгүй.” - *Еврей 13:5*

“... бvх замд чамайг хамгаалахын тулд Тэр Өөрийн тэнгэр элч нарт чиний талаар тушаал өгнө.”

- *Дуулал 91:11*

“... Эцэг бүхнээс агуу бөгөөд, тэднийг хэн ч Эцэгийн гараас булааж чадахгүй.”

- *Иохан 10:29*

“... Би та нартай үргэлж хамт байх болно.”

- *Матай 28:20*

“Эдлэх гэж буй зовлонгоосоо бүү ай ...

Үхэл хүртэл итгэмжтэй бай. Тэгээд Би чамд амийн титмийг өгнө.” - *Илчлэлт 2:10*

“Намайг дууд. Би хариулах болно ...” - *Иеремиа 33:3*



Бүх хүмүүс үжлээс амилах болно.

“... Учир нь булшинд байгчид бүгдээрээ Түүний дууг сонсон гарч ирэх цаг ирж байна. Сайн үйлийг үйлдсэн хүмүүс нь амийн амилалт уруу, муу үйлийг үйлдсэн хүмүүс нь ялын амилалт уруу гарч ирнэ.”

- *Иохан 5:28, 29*



Христ дотор үхэгсэд эхэнд амилна.

“Дараа нь амьд хийгээд үлдсэн бид тэдэнтэй хамт агаар мандалд Эзэнтэй уулзахаар үүлэн дотор өргөгдөж, тийнхүү Эзэнтэй үргэлж хамт байх болно.”

- *1 Тесалоник 4:17*

“Анхаар, сонор сэрэмжтэй байгтун. Учир нь тэрхүү товлосон цаг хэзээ байхыг та нар мэдэхгүй.”

- *Марк 13:33*

ЕСҮС ХЭРХЭН ДАХИН ИРЭХ ВЭ?



“Харагтун, Тэр үүлсийн хамт ирэх бөгөөд,
нүд бүр Түүнийг харна ...” *- Илчлэлт 1:7*

Худал христүүд ба худалч зөнч нар.

“Хэрэв хэн нэгэн та нарт, Харагтун, Христ
энд байна, эсвэл Тэнд гэвэл бүү итгэ ... Хараач,
Тэр цөлд байна, гэвэл бүү оч, эсвэл, Хараач, Тэр
дотоод өрөөнд байна гэвэл бүү итгэ.

- Матай 24:23, 26

ЕСҮС ТЭНГЭРИЙН ҮҮЛЭН ДЭЭР ИРНЭ

“Аянга зүүн зүгээс цахиж, баруун зүгт ч гялбуулдаг шиг Хүний
Хүүгийн заларч ирэх нь тийм байх болно ... Хүний Хүүг тэнгэрийн
үүлэн дээр сүр хүч болоод агуу цог жавхлантайгаар ирэхийг
харна.” *- Матай 24:27, 30*

ХОНЬЧИНЫ ДУУЛАЛ

(Дуулал 23)

ЭЗЭН бол миний хоньчин. Надад дутах зүйл нэг ч үгүй. Тэр намайг ногоон бэлчээрт хэвтүүлж дөлгөөн усны дэргэд аваачдаг. Тэр миний сүнсийг сэргээн Өөрийнхөө нэрийн төлөө зөв шударгын замд намайг хөтөлдөг.

Үхлийн харанхуй хөндийгөөр би туулавч хор хөнөөлөөс айхгүй. Учир нь Та надтай хамт байна. Таны таяг Таны саваа намайг тайвшруулдаг. Та миний толгойд тос түрхэж аяга минь дүүрч бялхадаг.

Сайн сайхан хийгээд хайр энэрэл насан туршид минь намайг лавтайяа дагана. Би ЭЗЭНий өргөөнд мөнхөд оршин суух болно.

